ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 16 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2024/143/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Ч.Баярсайхан
Утас: 89000060 Цахим хаяг:bayaraach85@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024. 02. 22 № 172

танай ______-ны № ______-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
16-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ГАНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 16-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 16-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайланд материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, үйл явдал гараагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Хэрлэн сумын 16-р цэцэрлэг нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 5 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас 90.7 хувиар дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

011001046

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **79,463,806.26** | **45,403,852.90** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **72,905,469.26** | **39,312,738.53** |
| **33** | **АВЛАГА** | - | **107,577.37** |
| **335** | **Бусад авлага** | **-** | **107,577.37** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 107,577.37 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6,558,337.00** | **5,983,537.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **3,560,211.00** | **3,560,211.00** |
| 35130 | Эм боох материал | 3,313,211.00 | 3,313,211.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 247,000.00 | 247,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **2,998,126.00** | **2,423,326.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 574,800.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 436,526.00 | 436,526.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,986,800.00 | 1,986,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **23,906,464.78** | **22,988,898.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 23,906,464.78 | 22,988,898.70 |
| **392** | **Биет хөрөнгө** | **23,194,214.78** | **22,507,648.70** |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 9,704,035.00 | 15,645,923.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,351,555.82) | (4,292,363.10) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,031,530.00 | 3,491,530.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (816,816.32) | (1,423,122.44) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 21,887,022.00 | 21,887,022.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (8,260,000.08) | (12,802,340.76) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **712,250.00** | **481,250.00** |
| 39301 | Програм хангамж | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (442,750.00) | (673,750.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **103,370,271.04** | **68,392,751.60** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **732,320.16** | |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 732,320.16 | - |
| **413** | **Өглөг** | 732,320.16 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 732,320.16 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **102,637,950.88** | **68,392,751.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **102,637,950.88** | **68,392,751.60** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 102,637,950.88 | 68,392,751.60 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 102,637,950.88 | 102,637,950.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (34,245,199.28) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **103,370,271.04** | **68,392,751.60** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **259,778,210.00** | **337,653,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **6,193,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | **6,193,900.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 6,193,900.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 6,193,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **19,126,310.00** | |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **240,651,900.00** | **331,459,700.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,524,310.00** | |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,524,310.00 | - |
| | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 15,602,000.00 | - |
| | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,602,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **194,552,794.05** | **371,898,799.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **194,552,794.05** | **371,898,799.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **191,028,484.05** | **371,898,799.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **144,895,066.09** | **276,046,917.21** |
| 210101 | Үндсэн цалин | 121,122,788.09 | 211,817,406.59 |
| 210102 | Нэмэгдэл | 17,111,167.00 | 57,215,115.63 |
| 210104 | Урамшуулал | 6,661,111.00 | 7,014,394.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,077,184.91** | **32,038,928.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,101,999.25 | 21,492,869.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,469,795.05 | 2,830,441.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,017,664.02 | 2,182,626.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 224,166.04 | 510,355.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,263,560.55 | 5,022,635.38 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **574,800.00** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 574,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **19,562,653.00** | **41,540,149.00** |
| 210502 | Хоол | 19,562,653.00 | 41,540,149.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **670,000.00** |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | - | 670,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,493,580.05** | **21,028,004.08** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,432,980.00 | 11,307,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 688,000.00 | 2,400,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,372,600.05 | 7,320,454.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,524,310.00** | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,524,310.00** | - |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,524,310.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **65,225,415.95** | **(34,245,199.28)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **65,225,415.95** | **(34,245,199.28)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **355,432,810.00** | **331,459,700.00** |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **355,432,810.00** | **331,459,700.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **336,306,500.00** | **331,459,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **336,306,500.00** | **331,459,700.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 336,306,500.00 | 331,459,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,524,310.00** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,524,310.00 | - |
| | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **15,602,000.00** | **-** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/ | 15,602,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **282,527,340.74** | **365,052,430.73** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **282,527,340.74** | **365,052,430.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **279,002,588.74** | **365,052,430.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **206,149,727.33** | **274,555,585.53** |
| 210101 | Үндсэн цалин | 162,490,032.52 | 197,812,215.76 |
| 210102 | Нэмэгдэл | 28,970,181.28 | 64,271,779.53 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 14,689,513.53 | 12,471,590.24 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **25,224,155.41** | **34,370,158.20** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,471,026.07 | 23,824,099.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,234,169.03 | 2,830,440.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,618,046.12 | 2,182,626.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 328,983.62 | 510,356.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,571,930.57 | 5,022,635.38 |
| **2105** | **Нормативт зардал** | **32,174,616.00** | **41,540,149.00** |
| 210502 | Хоол | 32,174,616.00 | 41,540,149.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,187,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,187,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **801,290.00** | **670,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 801,290.00 | 670,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,465,800.00** | **13,916,538.00** |
| **210901** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,215,800.00** | **11,586,438.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,250,000.00 | 2,330,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,524,752.00** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,524,310.00** | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,524,310.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **442.00** | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 442.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **72,905,469.26** | **(33,592,730.73)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **72,905,469.26** | **(33,592,730.73)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **72,905,469.26** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **72,905,469.26** | **39,312,738.53** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **102,637,950.88** | **102,637,950.88** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | **102,637,950.88** | **102,637,950.88** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | (34,245,199.28) | (34,245,199.28) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **68,392,751.60** | **68,392,751.60** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **388,396,900.00** | **365,052,430.73** | **23,344,469.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **388,396,900.00** | **365,052,430.73** | **23,344,469.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **388,396,900.00** | **365,052,430.73** | **23,344,469.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **298,942,200.00** | **274,555,585.53** | **24,386,614.47** |
| 210101 | Үндсэн цалин | 205,133,600.00 | 197,812,215.76 | 7,321,384.24 |
| 210102 | Нэмэгдэл | 87,464,400.00 | 64,271,779.53 | 23,192,620.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | - |
| 210104 | Урамшуулал | 6,344,200.00 | 12,471,590.24 | (6,127,390.24) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **37,368,000.00** | **34,370,158.20** | **2,997,841.80** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,410,100.00 | 23,824,099.00 | 1,586,001.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,989,400.00 | 2,830,440.42 | 158,959.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,391,500.00 | 2,182,626.46 | 208,873.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 597,900.00 | 510,356.94 | 87,543.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,979,100.00 | 5,022,635.38 | 956,464.62 |
| **2105** | **Нормативт зардал** | **38,875,100.00** | **41,540,149.00** | **(2,665,049.00)** |
| 210502 | Хоол хүнс | 38,875,100.00 | 41,540,149.00 | (2,665,049.00) |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **776,700.00** | **670,000.00** | **106,700.00** |
| 210806 | Мэдээлэл технологийн зардал | 776,700.00 | 670,000.00 | 106,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **12,434,900.00** | **13,916,538.00** | **(1,481,638.00)** |
| **210901** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,104,800.00** | **11,586,438.00** | **(1,481,638.00)** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,330,100.00 | 2,330,100.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **389,561,900.00** | **331,459,700.00** | **58,102,200.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **389,561,900.00** | **331,459,700.00** | **58,102,200.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 389,561,900.00 | 331,459,700.00 | 58,102,200.00 |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 72,905,469.26 | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 39,312,738.53 | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 18 | 18 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 16 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.0 сая төгрөгийн 2 алдаа[1]-г аудитын явцад залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Цалингийн татварын хөнгөлөлт тооцох тохируулах бичилтийг 1.6 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэж тайлагнасан. Энэ нь УСНББОУС 01, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- НДШ-ийн тайланд 0.4 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан. Энэ нь УСНББОУС 01, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2 зөрчил[2] илэрснээс 2 зөрчилд давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өглөө.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалтын гэрээтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Худалдан авалтын гэрээ хангалтгүй. Гэрээнд бараа материалын нэгжийн үнэ, авах барааны жагсаалт байхгүй байна. Энэ нь УСНББОУС 01, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Худалдан авалтын гэрээнд барааны үнийн жагсаалт хавсаргаж байх, гэрээний салшгүй нэг хэсэг болгох.

2. Бараа материалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Бараа материалын тооллогыг баримтын бүрдэл хангалтгүй хийсэн байна. Энэ нь УСНББОУС 01, оршин байх байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бараа материалын тооллогын анхан шатны баримтад тусган, чанартай хийж байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн татварын хөнгөлөлт тооцох тохируулах бичилтыг 1.6 сая төгрөгөөр зөрүүтэй | 1 | 1,582.4 | - | - | 1 | 1,582.4 | - | - | - | - | - | - |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| бүртгэж тайлагнасан. | | | | | | | | | | | | |
| НДШ-ийн тайланд 0.4 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан.. | 1 | 448.2 | - | - | 1 | 1,582.4 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **2,030.6** | - | - | **2** | **2,030.6** | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материалын тооллогыг баримтын бүрдэл хангалтгүй хийсэн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Худалдан авалтын гэрээ хангалтгүй. Гэрээнд бараа материалын нэгжийн үнэ, авах барааны жагсаалт байхгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | | | | |
| **Дүн** | **2** | - | - | **-** | - | - | **2** | **-** | **-** | **-** | **-** | **-** |